МЭДЭЭ · 2021 оны 4-р сарын 7

УЛСЫН ХЭМЖЭЭНД ГАРЧ БАЙГАА НИЙТ ЗӨРЧЛИЙН ДИЙЛЭНХ ХУВИЙГ ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ ЗӨРЧИЛ ЭЗЭЛЖ БАЙНА



Энэ оны 3 дугаар сард улсын хэмжээнд гарсан зөрчил өмнөх 2 дугаар сартай харьцуулахад 77.3 хувиар өссөн байна.

Улсын хэмжээнд 3 дугаар сард нийт 167276 зөрчлийн хэрэг бүртгэгдсэнээс 98.87 хувийг цагдаагийн байгууллага, 0.21 хувийг мэргэжлийн хяналт, 0.05 хувийг онцгой байдал, 0.86 хувийг бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд шалган шийдвэрлэжээ.

Дээрх хугацаанд зөрчил үйлдсэн 166116 хүн Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шийтгүүлсэн нь өмнөх сараас 78.4 хувиар, 237 хуулийн этгээд шийтгүүлсэн нь 75.6 хувиар тус тус өссөн байна.

Зөрчил үйлдсэн хүмүүсийн 78.8 хувь нь эрэгтэй, 21.2 хувь нь эмэгтэй байгаа бол 66.8

хувь нь 26-45, 0.17 хувь нь 16-18 насны хүн байна.

Зөрчлийн улмаас нийт 1 тэрбум 154 сая 884 мянган төгрөгийн хохирол учирч, 72.9 хувь нь нөхөн төлөгджээ.

Зарим төрлийн зөрчлийн гаралт нэлээдгүй хувиар өссөн байна. Тухайлбал, Мөрийтэй тоглох зөрчил 1 дахин, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил 86.2 хувиар, Хулгайлах зөрчил 38.5 хувиар, Хүний биед халдах зөрчил 25.6 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Өрсөлдөөний тухай хууль зөрчих зөрчил өмнөх сард гараагүй бол энэ сард 3 удаа гарчээ.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

ЗӨРЧЛИЙН ТООН МЭДЭЭ

2021.03.01-2021.04.01

Цагдаа	165399 98.87%	**Нийт зөрчил**	167276 ↑77.3%
Мэргэжлийн хяналт	359 0.21%		
Онцгой байдал	81 0.05%	Нийслэлд	128188 ↑1 дахин
Бусад	1437 0.86%	Орон нутагт	39088 ↑23.6%

www.prokuror.mn

Зөрчлийн улмаас учирсан хохирол	1.154.884 мян.төг	↑2.9 дахин
Төлөгдсөн хохирол	842.043 мян.төг	↑1.9 дахин
Шийтгүүлсэн хүн	166116	↑78.4%
Хуулийн этгээд	237	↑75.6%

130971 78.8%

35145 21.2%

0.17%	16-18 нас	26.4%	36-45 нас
14.7%	18-25 нас	12.9%	46-55 нас
40.4%	26-35 нас	5.2%	56-аас дээш нас

Өссөн зөрчил

Хулгайлах	54	38.5%
Хүний биед халдах	1485	25.6%
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	877	24.4%
Хүүхдийн эрхийг зөрчих	356	24.0%
Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах	6638	17.3%
Албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх	164	12.3%
Танхайрах	221	4.2%
Оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	828	2.2%

Буурсан зөрчил


Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих	192	37.9%
Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих	203	9.8%

Мөрийтэй тоглох	29	↑1.1 дахин
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	147951	↑86.2%

Харин Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих зөрчил 37.9, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих зөрчил 9.8 хувиар буурсан байна.


Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, Хүүхдийн эрхийг зөрчих, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчлийн дийлэнх хувь нь Нийслэлд үйлдэгдэж байна. Үүнээс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил, Хүүхдийн эрхийг зөрчих зөрчил Баянзүрх дүүрэгт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүрэгт хамгийн олон гарчээ.

Иргэд замын хөдөлгөөнд оролцохдоо эгнээ байр эзлэх журам зөрчих, хязгаарлалт тогтоосон захиргааны хэм хэмжээний актыг зөрчих зөрчлийг хамгийн их гаргасан байна.









Энэ төрлийн зөрчлийг үйлдсэн хүмүүсийн 79.1 хувь нь эрэгтэй, 40.9 хувь нь 26-35 насныхан байна.

Улсын хэмжээнд гарч байгаа нийт зөрчлийн дийлэнх буюу 85 орчим хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил эзэлж байгаа бөгөөд тоо хэмжээ нь буурахгүй, тогтмол өсөх хандлагатай байна. Иймд иргэдийг замын хөдөлгөөнд соёлтой, дүрмийн дагуу оролцон, бусдад болон өөртөө хохирол учруулахгүй байхыг уриалж байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2845